



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/414

Мөрөн сум

Бүтэц, орон тоо, дүрэм шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биеийн тамир спортын улсын хорооноос өгсөн чиглэл, засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Биеийн тамир спортын газрын бүтцийг нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар, орон тоог гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу төсөвтөө багтаан зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч, ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Б.Очирбат)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

4. Захирамж батлагдсантай холбогдуулан 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/315 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



ХӨВСГӨЛ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ДҮН ШИНЖИЛГЭЭ

2010 оны Бүтэц, орон тоо	Шинэчлэх бүтэц		
	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Орон тоо
Дарга	Дарга	ТЗ-4	1
Спорт, сургалт дасгалжуулалтын алба	Сургалт дасгалжуулалтын алба		
Ахлах дасгалжуулагч-албаны дарга	Спортын албаны дарга	ТҮСБ-5	1
Самбо, Жүдо дасгалжуулагч	Ахлах дасгалжуулагч, фитнесс, хүндийн өргөлт өвлийн спорт, шинэ тутам хөгжиж байгаа спортын төрөл	ТҮСБ-5	1
Үндэсний бөх, бөхийн чөлөөт барилдааны дасгалжуулагч	Жүдо, Самбо бөхийн дасгалжуулагч	ТҮСБ-4	1
Спорт тоглоомын дасгалжуулагч	Чөлөөт, үндэсний бөхийн дасгалжуулагч	ТҮСБ-4	1
Хөнгөн атлетик дасгалжуулагч	Спорт тоглоомын дасгалжуулагч	ТҮСБ-4	1
	Хөнгөн, Дугуйн дасгалжуулагч	ТҮСБ-4	1
	Бокс, гимнастикийн дасгалжуулагч	ТҮСБ-4	1
Санхүү аж ахуйн алба	Санхүү аж ахуйн алба		
Нягтлан бодогч-албаны дарга	Нягтлан бодогч-албаны дарга	ТҮ-8	1
Нярав	Заал зохион байгуулагч	ТҮСБ-3	1
Заал зохион байгуулагч	Архив бичиг хэрэг	ТҮ-5	1
Жолооч	Жолооч	ТҮ-3	1
Архив бичиг хэрэг	Жижүүр	ТҮ-1	4
Цахилгаанчин	Стадионы сахиул	ТҮ-1	1
Сантехникч	Үйлчлэгч	ТҮ-1	5
Жижүүр-3			
Үйлчлэгч -6			
Нийтийн биеийн тамир чийрэгжилтийн алба	Нийтийн биеийн тамир чийрэгжилтийн алба		
Ахлах арга зүйч-албаны дарга	Биеийн тамирын албаны дарга	ТҮСБ-5	1
Нийтийг хамарсан уралдаан тэмцээний арга зүйч	Нийтийг хамарсан уралдаан тэмцээний аргазүйч	ТҮСБ-4	1
Нийтийг хамарсан өдөрлөг, арга хэмжээний арга зүйч	Нийтийг хамарсан өдөрлөг, арга хэмжээний арга зүйч	ТҮСБ-4	1

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар
сарын 31-ний өдрийн 14.14 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Аймгийн Биеийн тамир, спортын газар цаашид (Газар гэх) –ийн бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна;

1.2 Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Биеийн тамир спортын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн Засаг даргын шийдвэр, энэхүү дүрмийг мөрдөж ажиллана;

1.3 Газар нь үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Аймгийн Засаг дарга болон Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайдын өмнө хариуцан тайлагнана;

1.4 Газар нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сангийн данстай байна.

Хоёр. Газрын эрхэм зорилго

2.1 Газрын зорилго нь Хөвсгөл аймгийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэж идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Газрын үйл ажиллагаанд баримтлах зарчим

3.1 Газар нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заасан төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална;

3.1.1 Байгууллагын үнэ цэн, нэр хүндийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх;

3.1.2 Иргэд үйлчлүүлэгчид болон хамтран ажиллагч байгууллага, харилцагчдаа хүндэлж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах;

3.1.3 Хүнд суртал, авлигал, хээл хахууль, шан харамжаас ангид байх.

Дөрөв. Газрын үндсэн чиг үүрэг

4.1 Газар нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ;

4.1.1 Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Аймгийн хэмжээнд зохион байгуулах;

4.1.2. Аймгийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.3 Аймагт биеийн тамир, спортыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.1.4. Сум, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дэх биеийн тамирын хамтлаг, арга зүйч, иргэдэд биеийн тамир, спортын ажлыг зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах;

4.1.5 Биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, уулзалт, семинар, хурал, зөвлөгөөн төрөл бүрийн сургалт, бусад арга хэмжээг аймагт зохион байгуулахад

мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

4.1.6 Биеийн тамир, спортын ажил үйлчилгээ барилга байгууламж, заал талбайн хэрэглэл, тоног төхөөрөмжийн чанар, стандарт боловсруулахад оролцох, хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.7 Эрүүл аж төрөх ёс, зан үйл биеийн тамир, спортын эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

4.1.8 Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар ном, гарын авлага, зөвлөмж, эмхэтгэл, зурагт хуудас гаргах, сургалт явуулах.

Тав. Газрын зохион байгуулалтын бүтэц

5.1 Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг, Аймгийн Засаг дарга батална;

5.2 Газрын бүтцийн нэгж үйл ажиллагааныхаа явц, үр дүнг газрын даргын өмнө хариуцан тайлагнана;

5.3 Газар нь хариуцсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж ажиллах бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөг Аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллана ;

5.4 Газар нь хууль тогтоомж, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг, даалгавар, төсөл, хөтөлбөр , Биеийн тамир спортын улсын хорооноос ирсэн албан бичгийг дагуу ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааны явц үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнана.

Зургаа. Удирдлага зохион байгуулалт

6.1 Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн төрийн албаны тухай хуулийн дагуу аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө;

6.2 Газрын удирдлагын тогтолцоо нь чиг үүргийн болон шугаман удирдлагатай хавсарсан хэлбэртэй байна;

6.3 Газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд Аймгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллах, үйл явц, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнах, газрын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах шугаман удирдлагын газрын дарга хэрэгжүүлнэ.

Долоо. Газрын даргын чиг үүрэг

7.1 Газрын дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ;

7.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах газрын хөдөлмөрийн дотоод журам боловсруулах, холбогдох дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;

7.1.2 Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд хууль, журмын дагуу албан хаагчдыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлуулах;

7.1.3 Хэлтсийн дарга, төрийн үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

7.1.4 Сахилга, дэг журам төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалт хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

7.1.5 Албан хаагчдын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.6 Хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтанд хандаж санал гаргах, шийдвэрлүүлэх;

7.1.7 Архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

7.1.8 Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйл хэрэгт тодорхой хувь нэмэр оруулсан байгууллага, хувь хүмүүсийг төр засгийн болон аймгийн шагналаар шагнуулах талаар хүсэлт, тодорхойлолт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;

7.1.9 Биеийн тамир, спортын хөгжлийг тодорхойлох статистикийн тоо, баримт тайлан мэдээг нэгтгэн дүгнүүлэх;

7.1.10 Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

1. СУРГАЛТ ДАСГАХУУЛАЛТЫН АЖАА

_____оОо_____

№	Албан тушаалын нэр	Орлог, үйл	Албан тушаалын амжилт
1	Спортын албаны дарга	1	ТХБ-4
2	Ахлах дасгалжуулагч, физикос, хүнсний аргаар, үнэмлэх спорт, шалт тусам хөгжсөн байгаа спортын төрөл	1	ТХБ-5
3	Жуу, Самбо, Бөхийн дасгалжуулагч	1	ТХБ-4
4	Хөдөл, үндэсний бөхийн дасгалжуулагч	1	ТХБ-4
5	Самбо, тугимын дасгалжуулагч	1	ТХБ-4
6	Хөдөл, дугуйн дасгалжуулагч	1	ТХБ-4
7	Бөх, гэмдүүлэх дасгалжуулагч	1	ТХБ-4
	Дүн		

2. САЙНГАЖ АХУЙН АЖАА

№	Албан тушаалын нэр	Орлог, үйл	Албан тушаалын амжилт
1	Нийслэл-албаны дарга	1	ТХБ-4
2	Хөдөл зохион байгуулагч	1	ТХБ-3
3	Самбо, бөхийн хөдөл	1	ТХБ-4
4	Хөдөл	1	ТХБ-4
5	Хөдөл	1	ТХБ-4
6	Утасны хөдөл	1	ТХБ-4
7	Хөдөл	1	ТХБ-4
	Дүн		

Аймгийн Засаг даргын 2023
оны 07 дугаар сарын 31-ний өдрийн
А/44 дугаар захирамжийн
гуравдугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Дарга	1	ТЗ

1. СУРГАЛТ ДАСГАЛЖУУЛАЛТЫН АЛБА

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Спортын албаны дарга	1	ТҮСБ-5
2	Ахлах дасгалжуулагч, фитнес, хүндийн өргөлт, өвлийн спорт, шинэ тутам хөгжиж байгаа спортын төрөл	1	ТҮСБ-5
3	Жүдо, Самбо бөхийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
4	Чөлөөт, үндэсний бөхийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
5	Спорт тоглоомын дасгалжуулагч	1	ТҮСБ-4
6	Хөнгөн, дугуйн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
7	Бокс, гимнастикийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
Дүн		7	

2. САНХҮҮ АЖ АХУЙН АЛБА

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Нягтлан /албаны дарга/	1	ТҮ-8
2	Заал зохион байгуулагч	1	ТҮСБ-3
3	Архив, бичиг хэрэг	1	ТҮ-5
4	Жолооч	1	ТҮ-3
5	Жижүүр	4	ТҮ-1
6	Стадионы сахиул	1	ТҮ-1
7	Үйлчлэгч	5	ТҮ-1
Дүн		14	

3. НИЙТИЙН БИЕЙН ТАМИР ЧИЙРЭГЖИЛТИЙН АЛБА

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал
1	Биеийн тамир албаны дарга	1	ТҮСБ-5
2	Нийтийг хамарсан уралдаан тэмцээний арга зүйч	1	ТҮСБ-4
3	Нийтийг хамарсан өдөрлөг арга хэмжээний арга зүйч	1	ТҮСБ-4
Дүн		3	

___оОо___

Дарга /*[Signature]*/ П.ХАГБАЖАВ